БАТЛАВ:
НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР

Ч.ТӨГСДЭЛГЭР

СҮХБААТАРЫН ТАЛБАЙ ОРЧМЫН НИЙТИЙН ТЭЭВРИЙН ЗАНГИЛАА ТӨВ БАЙГУУЛАХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ, ТӨСӨВ, БОЛОВСРУУЛАХ ТӨЛӨВЛӨЛТИЙН ДААЛГАВАР

2026 оны 03 дугаар сарын 11 Дугаар: 2026/01 Улаанбаатар хот

1.	Төслийн үндэслэл	- "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого - "Шинэ сэргэлтийн бодлого"; - "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг"; - "Улаанбаатар хотын 2040 хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал" - "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"; - Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр; - Улаанбаатар хотын нийтийн тээврийн системийг хөгжүүлэх дунд болон урт хугацааны бодлогын баримт бичиг, нийтийн тээврийн сүлжээний мастер төлөвлөгөө; - Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны .... тогтоол;
2.	Байршил, Эдэлбэр газрын хэмжээ	- Нийслэл Улаанбаатар хот Сүхбаатар дүүргийн 1, 2, 6, 8 дугаар хороо, Чингэлтэй дүүргийн 1, 4 дүгээр хорооны нутаг дэвсгэр; - Төсөл хэрэгжүүлэх талбай 2.3 га; - Хавсралт-1 (Төлөвлөлтийн хамрах хүрээ 600 метр)
3.	Зорилго	- Сүхбаатарын талбай орчимд төлөвлөж буй их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл болох метро, трамвай, дүүжин зам, тусгай замын автобус болон автобусны сүлжээг нэгтгэсэн олон төрлийн нийтийн тээврийн зангилаа төв байгуулах; - Нийтийн тээврийн хөдлөх бүрэлдэхүүний зохион байгуулалт, ашиглалтын үр ашгийг дээшлүүлж, зорчигч урсгалын шилжилт хөдөлгөөнийг оновчтой зохицуулсан төлөвлөлтийг хэрэгжүүлэх; - Хот төлөвлөлт болон нийгэм-эдийн засгийн хөгжлийн бодлоготой уялдуулан нийтийн тээвэрт суурилсан (TOD) төлөвлөлтийг үе шаттайгаар хэрэгжүүлэх;
4.	Зориулалт, хүчин чадал	- Улаанбаатар хотын нийтийн тээврийг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй төслүүдийн ТЭЗҮ-д тусгагдсан хэтийн тээврийн эрэлтийн тооцоололд үндэслэн, цаашдын өсөлтийн нөөцийг харгалзан хүчин чадлын тооцооллыг тодорхойлох;
5.	Одоогийн байдал	Төлөвлөлтийн талбай нь: - Одоогийн байдал нь нэг түвшний уулзвар, зам талбай зогсоол, ногоон байгууламж бүхий нийтийн эзэмшил.

6.	Төсөл боловсруулах үе шат	*1-р үе шат;* **Суурь судалгаа:** - Байр зүйн дэвсгэр зураг зохиох М1:500 масштаб; - Инженер-геологийн дүгнэлт М1:1000 масштаб; - Хөрсний усны судалгаа; **Зураг төсөл:** - Загвар зураг; - Анимэйшн 3 доошгүй минут; - Макет; *2-р үе шат;* **Ажлын зураг:** - Иж бүрэн ажлын зураг; - Гадна зам талбайн тохижилтын ажлын зураг; - Гадна инженерийн шугам сүлжээ; - Авто зам, замын байгууламжийн ажлын зураг; - Нэгдсэн төсөв;
7.	Төслийн захиалагч	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар; Нэгдсэн төслийн удирдлагын газар ОНӨТҮГ;
8.	Төсөл боловсруулах байгууллага	Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавих нөхцөл, шаардлага ЗТ-4.5, ЗТ-4.5, ЗТ-4.10, ЗТ-5.1, ЗТ-5.2, ЗТ-6.1, ЗТ-6,2, ЗТ-6.3, ЗТ-6.4, ЗТ-7.1, ЗТ-7.1, ЗТ-9.1, ЗТ-10.2, Эрчим хүчний тусгай зөвшөөрөлийн ТЗ-8, Авто зам, замын байгууламжийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж түншлэлээр оролцох боломжтой.
9.	Архитектур орон зайн төлөвлөлтөд тавигдах шаардлага	**Архитектур орон зай:** - Хотын нийтийн тээврийн орон зайг трамвай, метро, дүүжин тээвэр, тусгай замын автобус, одоогийн нийтийн тээвэр, такси болон бичил тээврийн хэрэгслийн зохицуулалтыг бүрэн хангасан байна; - Хотын харагдах байдал болон үзэгдэх орон зайг алдагдуулахгүй байхаар төлөвлөх; - Газар доорх байгууламжийн орц гарцын архитектур-зохиомжийн шийдлийг үндэсний соёлын хэв шинжийг агуулсан байх; - Нийтийн тээврийн хэрэгслээс бусад тээврийн хэрэгсэлд /хувийн автомашины зогсоол бүхий давхрыг газар доор шийдэх/ дамжин суух байгууламж /ITF/ оновчтой шийдлийг тодорхойлох; - Замын хөдөлгөөний оргил ачааллын үед зорчигч урсгалын чиглэл, тархалт болон нягтралын үзүүлэлтүүдийг тодорхойлж, үнэлгээ хийх; - Тээврийн зангилаа төвийн байгууламжийн зорчигч урсгал хүлээн авах хүчин чадал, үйл ажиллагааны багтаамжийг тодорхойлж үнэлгээ хийх; - Зогсоолын байршил, зорчигч хүлээн авах талбайн суух, буух хэсгийн орон зайн төлөвлөлт, бусад тээврийн системүүд хооронд шилжин зорчих зохицуулалтыг боловсруулах; - Газрын түвшний төлөвлөлтөд нийтийн тээвэр хэрэгслүүдийн (трамвай, автобус 10.4-18 метр урттай) эргэлтийн радиусыг тооцож төлөвлөлтийн шийдлийг оновчтой боловсруулах;

		- Төвийн бүсэд автомашины зогсоолын төлөвлөлт; **Хөдөлгөөн төлөвлөлт орц, гарц:** - Нийтийн болон хувийн тээврийн хэрэгслийн орох гарах дараалыг оновчтой төлөвлөх; - Уулзварын огтлолцлыг тээврийн хэрэгслийн хөдөлгөөнтэй уялдуулан оновчтой төлөвлөх; /3-аас доошгүй хувилбараар боловсруулж захиалагчтай зөвшилцөх/ - Авто зогсоолын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн орц гарцыг уялдуулан зураг төсөлд тусгах; - Явган хүний хөдөлгөөнийг тасралтгүй үргэлжилсэн байхаар төлөвлөж, зорчих хөдөлгөөнийг хүртээмжтэй байдлаар саадгүй зорчих нөхцөлийг бүрдүүлсэн байх; **Ландшафт төлөвлөлт:** - Өндөржилт, катограмм, хөрсний хэв шинж, бүтцэд тохирсон ногоон байгууламжийн төлөвлөлтийн шийдлийг боловсруулах; - Хаягжуулалт, мэдээллийн самбар төлөвлөх; - Төслийн орчны гадна тохижилтыг цогцоор нь төлөвлөх; **Гэрэлтүүлэг:** - Авто зам болон явган хүний зам талбайн гэрэлтүүлгийг байгаль цаг уурын нөхцөлд нийцүүлэн шийдэх; - Байгаль орчинд ээлтэй эрчим хүчний хэмнэлттэй байхаар төлөвлөх; - Орчин үеийн дэвшилтэд техник технологийн шийдлийг тусгасан байх; **Эдийн засгийн тооцоо:** - Хэрэгжүүлэхээр тооцсон төсөл, хөтөлбөрийн судалгааг хийж тусгах; - Холбогдох норм, дүрэмд нийцсэн төлөвлөлттэй эрчим хүчний хэмнэлттэй, ашиглалтын зардал бага байх; - Нэгдсэн төсөв /estimator эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцох/ **Гамшгийн менежмент:** - Гамшгийн аюулд өртөх эрсдэлтэй газрыг тогтоож, цаашид авах арга хэмжээг тодорхойлж, төлөвлөх; - Нүүлгэн шилжүүлэлтийн үеийн зорчигч урсгалын загварчлал, тооцоолол боловсруулах; **Ногоон байгууламж:** - Цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийг төлөвлөхдөө бичил уур амьсгалын тааламжтай орчин бий болгож, нутаг дэвсгэрийн онцлог архитектур орон зайн зохиомжийг оновчтой төлөвлөх; - Ногоон байгууламжийн төлөвлөлтийг “Тэрбум мод” хөтөлбөртэй уялдуулсан байх;
10.	Инженерийн дэд бүтэц	**Инженерийн бэлтгэл арга хэмжээ:** - Талбайд орчны судалгаа, инженер геологи, гидрогеологи, гидрологи, инженер геодези, ус зүйн тооцоо судалгаа хийх - Авто замын борооны ус зайлуулах шугам сүлжээг гидрологийн тооцоонд үндэслэн төлөвлөх - Усны барилга байгууламжийн холболтын цэгийг ашиглагч “ГУББГ,ОНӨААТҮГ”-аас техникийн нөхцөл авах

		- Шугамын трасст орсон барилга байгууламж, нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн тохижилт, авто замын нөхөн сэргээлтийг төсөвт тусган тооцоо, судалгааг нарийвчлан гаргах **Дулаан хангамж:** - Төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээнээс хангагдана; - Хангагч байгууллагаас шугам сүлжээний тодруулга авах холболтын тодорхойлох /УБДС,ОСНААУГ /; - Одоо байгаа дулааны шугамд холбогдсон хэрэглээг тодорхойлох, нэвтрүүлэх чадварын тооцох; - Дулаан хангамжийн хэрэглээний тооцоо, одоо байгаа шугам сүлжээний хүчин чадалтай уялдуулан төлөвлөх; - Дулаан хангамжийн системийг Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор эрчим хүчний хэмнэлттэй байх техникийн шийдлийг гаргах; - Эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламж төлөвлөх; **Ус хангамж:** - Ус хэрэглээний тооцоо, гидравлик тооцоог норм дүрмийн дагуу тооцох; - Хангагч байгууллагаас олгосон техникийн нөхцөл, техникийн тодруулгын дагуу холболтын цэг тодорхойлох /УСУГ, ОСНААУГ / - Ус хэрэглээний тооцоо, инженер геологийн дүгнэлтийг үндэслэн шугам сүлжээг хөлдөлтөөс хамгаалах арга хэмжээ авч төлөвлөх; - Одоо байгаа шугам сүлжээг шаардлагатай тохиолдолд зөөж шилжүүлэх, хүчитгэх арга хэмжээг авах; - Бусад шугам сүлжээтэй уялдуулан шаардлагатай тохиолдолд хонгилийн систем төлөвлөх **Ариутгах татуурга:** - Одоо байгаа шугам сүлжээг шаардлагатай тохиолдолд зөөж шилжүүлэх, хүчитгэх арга хэмжээг авах; - Хангагч байгууллагаас олгосон техникийн нөхцөл, техникийн тодруулгын дагуу холболтын цэг тодорхойлох /УСУГ, ОСНААУГ / **Цахилгаан хангамж:** - Төлөвлөлтийн талбайд өртөж байгаа цахилгаан хангамжийн шугам сүлжээний тодруулгыг хангагч байгууллагаас авч төлөвлөлтийг хийхдээ уялдуулан төлөвлөх. - Төлөвлөлтийн цахилгаан ачааллыг мөрдөгдөж байгаа норм дүрмийн дагуу тооцож хангах боломжийг судлах, хангагч байгууллагаас санал авч төлөвлөлтөд тусгах; - Одоо байгаа шугам сүлжээг зөөж шилжүүлэх шаардлагатай тохиолдолд хангагч байгууллагаас өгсөн тодруулгын дагуу зөөж шилжүүлэх боломжийг судлах; **Мэдээлэл холбоо, дохиолол:** - Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ны худаг сувагчлалын сүлжээнд холбох;

		- Дохиолол хяналтын нэгдсэн сүлжээ төлөвлөх; - Гамшгийн үеийн зарлан мэдээлэх систем төлөвлөх; **Авто зам, талбай:** - Гудамж, замын сүлжээний төлөвлөлтийн дахин зохион байгуулахдаа нийтийн тээврийн системд нийцүүлж өнөөгийн авто замын өөрчлөлт, шинэчлэлт, барилга угсралтын дараалыг оновчтой төлөвлөх;
11.	Төсөл боловсруулахад ашиглах материал	**Монгол Улсын хуулиуд:** - Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж,түүний удирдлагын тухай хууль; - Соёлын өвийг хамгаалах тухай хууль; - Авто замын тухай хууль; - Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль; - Авто тээврийн тухай хууль; - Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүнтэй удирдлагын тухай хууль; - Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга; - Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль; - Хот байгуулалтын тухай хууль; - Газрын тухай хууль; - Барилгын тухай хууль; - Авто замын тухай хууль; - Авто тээврийн тухай хууль; - Усны тухай хууль; - Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай; - Эрчим хүчний тухай хууль; - Монгол Улсын агаарын чанарын тухай хууль; - Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль; - Инновацын тухай хууль; - Бусад холбогдох хууль тогтоомжууд; **Төсөл, хөтөлбөрүүд:** - Улаанбаатар хөнгөн галт тэрэг буюу "Трам" төсөл; - Улаанбаатар хотын тээврийг сайжруулах "Тусгай замын автобус (BRT)" нэвтрүүлэх төсөл; - Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл "Метро"-г барьж байгуулах төсөл; - Нийслэлийн нийтийн тээвэрт "Дүүжин замын тээвэр" нэвтрүүлэх төсөл; **Норм, нормативууд:** - Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм (БНбД 30-01-04); - Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах заавар (БД 30-103-21); - Хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах аргачилсан заавар (УББ 11-202-00); - Барилга байгууламжийн инженер-экологийн судалгаа (БД 11-102-07); - Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм; - Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт БНбД 23.01.09;

		- Халаалт, агаар сэлгэлт ба кондинционер БНбД 41-01-11; - Барилга байгууламжийн галын аюулгүй байдал БНбД 20-01-02; - Дулааны сүлжээ БНбД 41-02-13; - Дулааны шугам сүлжээ БНбД 3.05.03-95; - Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт БНбД 23-01-09; - Халаалт, агаар сэлгэлт ба кондинционер БНбД 41-01-11; - Тоног төхөөрөмж ба дамжуулах хоолойн дулаан тусгаарлалт БНбД 41-04-13; - Ус хангамж, гадна сүлжээ ба байгууламж БНбД 40-02-16; - Ариутгах татуурга. Гадна сүлжээ ба байгууламж БНбД 40-01-14; - Барилга доторхи ус хангамж, ариутгах татуурга БНбД 40-05-16*/20;
12.	Төслийн иж бүрдэл	**Суурь судалгаа:** - Байр зүйн дэвсгэр зураг зохиох М1:500 масштаб; - Инженер-геологийн дүгнэлт М1:1000 масштаб; - Хөрсний усны судалгаа; **Зураг төсөл:** - Загвар зураг; /концепцыг 2-оос доошгүй хувилбараар/ - Нийтийн болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөний схем; - Тохижилтын зураг төсөл; **Иж бүрэн ажлын зураг:** - Барилга архитектур; - Барилга бүтээц; - Халаалт агаар сэлгэлт; - Цэвэр, бохир ус; - Цахилгаан хангамж; - Автомат удирдлагын систем; - Мэдээлэл холбоо дохиолол; - Нэгдсэн төсөв; **Гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг:** - Дулаан хангамж; - Цахилгаан хангамж; - Мэдээлэл холбооны сүлжээ; - Усан хангамж, ариутгах татуурга; - Инженерийн бэлтгэл арга хэмжээ; - Нэгдсэн төсөв; **Инженерийн шугам сүлжээний шилжүүлэх, хүчитгэх хамгаалах ажлын зураг:** - Дулаан хангамж; - Цахилгаан хангамж; - Мэдээлэл холбооны сүлжээ; - Усан хангамж, ариутгах татуурга; - Инженерийн бэлтгэл арга хэмжээ; - Нэгдсэн төсөв; **Авто зам, замын байгууламжийн ажлын зураг:** - Авто замын зураг төсөл; - Замын байгууламжийн зураг төсөл; **Зураг төсөлд тавигдах шаардлага:** - Зураг төслийн баримт бичиг 5 хувь;

		- Ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн зургийг UTM-координатын системд хийж гүйцэтгэнэ; - Тайлбар бичиг /.doc, .pdf/ - Товч танилцуулга 25-аас ихгүй слайд байх/.ppt/ - Анимэйшн 2 минутаас багагүй байх./.mp4; 1080HD/ - Харагдах байдал /*.skp, lumion, *.max, *.rvt/ - Ажлын үе шатны зураглалын бүрдэл /.dwg, *.pdf, *.jpg/
13.	Санхүүжилт	- Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт;
14.	Зөвшилцөх байгууллага	- Хот байгуулалт, хотын стандартын газар; - Нийслэлийн Замын хөгжлийн газар; - Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба; - Нийтийн тээврийн бодлогын газар; - Инженерийн шугам сүлжээний ашиглагч байгууллага; - Нэгдсэн төслийн удирдлагын газар; - Бусад;
15.	Онцгой нөхцөл	- Тусгай хэрэгцээт иргэд, ахмад настан, бага насны хүүхдэд ээлтэй, аюулгүй таатай орчин бүрдүүлэх нэгдсэн төлөвлөлтийн шийдлийг (Universal Design) тусгах; - Ирээдүйн хүн амын өсөлтөд нийцүүлэн орон зайн өргөтгөх боломжийг бүрдүүлэх; - Зураг төслийн ажлын жишиг үнэ БД81-16-20-н хүснэгт 8-д тусгагдсаны дагуу өндөр шаардлагатай технологийн зураг төслийг боловсруулах; - Ажлын зураг төсөл боловсруулах бэлтгэл арга хэмжээний хүрээнд захиалагч байгууллага гадна инженерийн шугам сүлжээний техникийн нөхцөлийг хангагч байгууллагад хандан шийдвэрлэсэн байх; - Байгаль орчныг хамгаалах, хөрс, ус, агаарын бохирдлыг бууруулах технологи, хог хаягдлын менежментийн шийдэл тусгах; - Нийтийн тээвэрт суурилсан хөгжүүлэлтийн /TOD/ боломжуудыг тодорхойлох; - Ухаалаг дижитал технологийн шийдлийг нэвтрүүлэх; - Барилга угсралтын тавбайн зохион байгуулалтын төлөвлөлтийн шийдлийг тусгах; - Одоо байгаа барилга байгууламжийг хонгилын системээр холбох боломжийн судалж төлөвлөлтийн шийдэлд тусгах; - Шинэ техник технологийн шийдлийн тусгахаар бол манай орны нөхцөл ашиглах эрх зүйн орчны бүрдүүлнэ;

ЗӨВШӨӨРСӨН:

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Т.ОЮУНЧИМЭГ

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗРЫН ДАРГА Г.БАЯРСАЙХАН

НИЙСЛЭЛИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АЛБАНЫ ДАРГА Г.МӨНХБААТАР

НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА Б.ОДБАЯР

НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА Г.БИЛГҮҮН

УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН ГАЗРЫН ДАРГА
/ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР/ Л.АЛТАНГЭРЭЛ

“НЭГДСЭН ТӨСЛИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР” ОНӨТҮГ”-ЫН
ЗАХИРАЛ Э.ТҮВШИНЖАРГАЛ

“НЭГДСЭН ТӨСЛИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР” ОНӨТҮГ
УЛААНБААТАР МЕТРО ТӨСЛИЙН ЗАХИРАЛ Т.МӨНХДАЛАЙ

“НЭГДСЭН ТӨСЛИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР” ОНӨТҮГ
УЛААНБААТАР ТРАМ ТӨСЛИЙН ЗАХИРАЛ Б.АНУ-ҮЖИН

НЭГДСЭН ТӨСЛИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР” ОНӨТҮГ
ДҮҮЖИН ТЭЭВЭР ТӨСЛИЙН ЗАХИРАЛ Б.ДАМБАРАГЧАА

“НЭГДСЭН ТӨСЛИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР” ОНӨТҮГ
ТУСГАЙ ЗАМЫН АВТОБУС ТӨСЛИЙН ЗАХИРАЛ Т.ЧИНБАТ

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗРЫН
ЕРӨНХИЙ АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА Г.ХОСБАЯР

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗРЫН
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН
ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Ц.ЛХАМСҮРЭН

БОЛОВСРУУЛСАН:

“НЭГДСЭН ТӨСЛИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР” ОНӨТҮГ”-ЫН
ТӨСӨЛ ДЭМЖИХ МЕНЕЖМЕНТИЙН АЛБАНЫ
АХЛАХ ИНЖЕНЕР Ж.ЛХАГВАДОРЖ

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗРЫН
ЕРӨНХИЙ АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛБАНЫ
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Д.АДЪЯА

ГАЗРЫН БАЙРШИЛ	ОРЧНЫ ТОЙМ	ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭМЖЭЭ	ТӨСЛИЙН НЭР
Нийслэл Улаанбаатар хот Сүхбаатар, Чингэлтэй дүүрэг	Сүхбаатарын талбай Энхтайваны өргөн чөлөө	2.3 ГА	Сүхбаатарын талбай орчмын нийтийн тээврийн зангилаа төв байгуулах барилга байгууламжийн зураг, төсөв боловсруулах ажил

ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЯЗГААР СХЕМ ЗУРАГ

(Дугаар: 2026/...-.... ажлын даалгаврын хавсралт)



Тусгаг: WGS 1984 UTM Zone 48N

Таних тэмдэг

Масштаб: 1:5000

ХОТ БАЙГУУЛАЛТ,
ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР
ЕРӨНХИЙ АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛБА

Дүүргийн хил
Хороодын зааг
Баригдсан барилга
Авто зам
Нэгж талбар
Төлөвлөлтийн хил
Төлөвлөж буй метроны буудал / газар доорх /
Хамрах хүрээ / 600м /